



“ШИНЭ ҮЕИЙН ЗАЛУУ СУДЛААЧ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

Үндэслэл:

Монгол улсын их сургууль (МУИС) үүсгэн байгуулагдсаны 80 жилийн ой, Ахисан түвшний сургалт эрхэлсний 30 жилийн ойд зориулан, “NUM Science Festival 2022” арга хэмжээний хүрээнд МУИС-ийн судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийж буй суралцагчдыг шинжлэх ухааны тулгамдсан асуудлаар судалгааны үр дүнгээ илтгэх, залуу судлаачдыг дэмжих зорилгоор “ШИНЭ ҮЕИЙН ЗАЛУУ СУДЛААЧ” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулна.

Хамрах хүрээ:

- ✓ МУИС-ийн ахисан түвшний суралцагчид
- ✓ Бакалаврын түвшний суралцагчид

Хурлын үе шат

Эрдэм шинжилгээний хурлыг дараах 3 үе шаттайгаар зохион байгуулна.

- 1-р шат.** 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл **Тэнхимүүдийн эрдэм шинжилгээний хурал** зохион байгуулагдана. Тэнхимүүд хариуцан зохион байгуулна.
- 2-р шат.** 2022 оны 04 дүгээр сарын 26-нд **Салбар хуралдаан**: 1-р шатанд шалгарсан илтгэлүүдийг байгаль, нийгэм, хүмүүнлэг, инженерчлэлийн салбар тус бүрээр Бүрэлдэхүүн сургуулиуд хамтран зохион байгуулна.
- 3-р шат:** 2022 оны 05 дугаар сарын 11-нд “Шинэ үеийн залуу судлаач” эрдэм шинжилгээний нэгдсэн хурлыг зохион байгуулна.

Салбар хуралдаан

Салбар хуралдаан тус бүрд ахисан түвшний суралцагчдын судалгааны ажлын чиглэлээс хамааран Тэнхимийн эрдэм шинжилгээний хурлаас шалгарсан нэг илтгэгчийг оролцуулна.

Салбар хуралдаанд оролцох боломжтой чиглэл:

Бүрэлдэхүүн, салбар сургуулийн нэр	Байгаль шинжлэл	Нийгэм	Хүмүүнлэг	Инженерчлэл
Бизнесийн сургууль		+		
Хууль зүйн сургууль		+	+	
ОУХНУС		+	+	
ХШУИС	+			+
ШУС-БУС	+			+
ШУС-НУС		+	+	
ШУС-ХУС		+	+	



Салбар хуралдаанд оролцох илтгэгчдийн мэдээлэл, илтгэлийн материалыг тэнхимүүд **2022 оны 04 дүгээр сарын 25-ны дотор** grad_research@num.edu.mn хаягаар ирүүлнэ.

Салбар хуралдаан нь дараах байдлаар зохион байгуулагдана.

Салбар хуралдааны чиглэл	Хэзээ	Хаана
Байгаль шинжлэл	2022.04.26 Мягмар гараг	Хичээлийн төв байр, Эрдмийн танхим
Нийгэм		Номын сангийн байрны 502 тоот
Хүмүүнлэг		Хичээлийн 5-р байр, 605 тоот
Инженерлэл		Номын сангийн байрны 203 тоот

Салбар хуралдаанд оролцох илтгэлд тавигдах шаардлага:

- ✓ Судалгааны ажлын агуулга, зорилго, дүгнэлт (40 оноо)
 - Шинэлэг санаа дэвшүүлсэн, шинжлэх ухааны судалгааны онол, арга зүйн үндэслэлтэй байдал
 - Асуудал дэвшүүлж, зорилгодоо хүрсэн, аливаа дүгнэлт, зөвлөмжийн шийдэл бүхий байдал г.м
- ✓ Илтгэлийн чанар (20 оноо)
 - Слайдны мэдээлэл, загвар, дизайн г.м
- ✓ Илтгэх ур чадвар (20 оноо)
 - Цаг баримтлал, илтгэл тавих илэрхийлэмж г.м
- ✓ Асуултад хариулсан байдал (20 оноо)
- ✓ Илтгэл тавих хугацаа: 15 минут
 - Оршил (судалгааны ажлын зорилго, зорилт, үндэслэл) – 2 мин
 - Судалгааны арга зүй, боловсруулалт – 3 мин
 - Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг – 8 мин
 - Дүгнэлт, зөвлөмж – 2 мин
- ✓ Асуулт, хариулт: 7-8 мин

**“Шинэ үеийн залуу судлаач”
эрдэм шинжилгээний нэгдсэн хурал**

Зохион байгуулалт:

- ✓ 2022 оны 05 дугаар сарын 11-нд зохион байгуулагдах ба 2-р шатны салбар бүрээс шалгарсан ахисан түвшний суралцагчдын шилдэг 2 илтгэлийг тус бүр хэлэлцүүлнэ.
- ✓ Тэнхимийн эрдэм шинжилгээний хурлаас шалгарсан бакалаврын түвшний оюутнуудын шилдэг бүтээлүүдийг ханын илтгэл хэлбэрээр хуралд оролцуулна.



Шагналт байр:

“Шинэ үеийн залуу судлаач” эрдэм шинжилгээний нэгдсэн хуралд илтгэл хэлэлцүүлсэн шилдэг илтгэгчдэд дараах шагнал, урамшууллыг гардуулна.

- ✓ Ахисан түвшний шилдэг илтгэлд:
 - Магистрантын эрдэм шинжилгээний ажлын 2 багц цагийн төлбөрийн хөнгөлөлт
 - Докторантын эрдэм шинжилгээний ажлын 4 багц цагийн төлбөрийн хөнгөлөлт
- ✓ Бакалаврын түвшний ханын илтгэлд:
 - Шалгарсан ханын илтгэлд урамшуулал олгоно.

Шилдэг илтгэлүүдийг хэвлүүлэх:

Ахисан түвшний суралцагчдын илтгэлийг өргөтгөсөн хураангуй хэлбэрээр, бакалаврын түвшний ханын илтгэлүүдийг “МУИС-д суралцагчдын эрдэм шинжилгээний бүтээл”-д хэвлүүлнэ.

А. Ахисан түвшний суралцагчдын өргөтгөсөн хураангуйд тавигдах шаардлага

Илтгэлийг өргөтгөсөн хураангуй хэлбэрээр монгол хэл дээр 3-4 нүүр бүхий 1500 үгэнд багтаан бичих ба цаасны хэмжээ А4, захыг бүх талаас 2 см зайтай, үндсэн текстийн хэмжээ нь Times New Roman 11 фонтоор, мөр хоорондын зай Single, 4 талаас тэгш (Justify) байна.

Өргөтгөсөн хураангуй нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Удиртгал (үндэслэл, зорилго, зорилт);
- Судалгааны талбай, аргазүй,
- Үр дүн ба хэлэлцүүлэг
- Дүгнэлт
- Талархал
- Эшлэл

Өргөтгөсөн хураангуйд тавих шаардлага:

- ✓ Бүтээлийн сэдэв: Times New Roman 12, Bold, том (Uppercase) үсгээр бичнэ.
- ✓ Илтгэгчийн болон удирдагчийн овог нэр: Илтгэлийн нэрийн баруун доор Times New Roman 10 хэмжээгээр Bold, Italic горимоор бичнэ. Харьяалагдах сургууль, холбоо барих цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэргийг тусгасан байна.
- ✓ Түлхүүр үгс: Тухайн судалгааны онцлог, агуулгыг илэрхийлэх 5 хүртэл үг байна.
- ✓ Хураангуй нь хүснэгт 1-2, зураг 1-2 тус тус агуулж болно. Зургийн хэмжээ хамгийн томдоо А5 нүүрний тал хүртэл байна. Зургийн тайлбар нь Arial 10 хэмжээгээр зургийн доор оруулсан байна. Хүснэгтийн нэрийг Arial 10 хэмжээгээр хүснэгтийн дээр оруулна.

Үндэслэл, арга зүй хэсэгт эшлэл оруулсан бол эшлэлийг Mongolian Journal of Biology сэтгүүлийн эшлэл авах форматын адил оруулна.



Б. Бакалаврын түвшний суралцагчдын ханын илтгэлд тавигдах шаардлага

- ✓ Судалгааны ажил нь сэдэвтэй зохицсон байх
- ✓ Бичвэр 20%, зураг, график дүрслэлтүүд 40%, хоосон орон зай, туслах дүрслэлтүүд 40% байна.
- ✓ Илтгэлийн загвар, дизайн, өнгөний зохицолгоог сайн бүрдүүлсэн байх
- ✓ Үсгийн фонт Times New Roman байх ба үсгийн хэмжээг дараах байдлаар
 - Гарчигны үсгийн хэмжээ 70-100
 - Зохиогчдын нэрс, харьяаллыг 50-аас доош
 - Дэд гарчгууд 30-50
 - Үндсэн бичвэр 28-35, зураг графикийн тайлбар 18-24 байна.
- ✓ Ханын илтгэлийн бүтэц нь
 - Сэдэв
 - Илтгэгчийн болон удирдагчийн овог нэр, харьяалал
 - Удиртгал
 - Судалгааны талбай, арга зүй
 - Үр дүн ба хэлэлцүүлэг
 - Дүгнэлт
 - Талархал
 - Ном зүй
 - Ханан илтгэлийн цаасны хэмжээ A0, босоо байрлалтай байна.
- ✓ Ханын илтгэлийг зориулалтын самбарт хурлын өмнөх өдөр байрлуулж хурлын үйл ажиллагааны туршид байлгана.
- ✓ Хурлын хөтөлбөрт тусгасан хугацаанд илтгэгч нар илтгэлээ танилцуулна.

Илтгэлийн өргөтгөсөн хураангуй, ханын илтгэлийг хүлээн авах цахим хаяг:

Суралцагчид “МУИС-д суралцагчдын эрдэм шинжилгээний бүтээл”-д хэвлүүлэх бүтээлээ Ахисан түвшний сургуулийн мэргэжилтний grad_research@num.edu.mn хаягаар **2022 оны 04 дүгээр сарын 29-ний дотор** ирүүлсэн байна.

АХИСАН ТҮВШНИЙ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ



Н.БААТАРБИЛЭГ